БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 10 сарын 06 өдөр Дугаар А/218 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/77, 2026 оны А/503 дугаар захирамж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны А/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн Засаг даргын 2026 оны А/192 дугаар захирамжаар зарлагдсан газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтыг үнэлж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтыг “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-ын дагуу зохион байгуулахыг Ажлын хэсэг (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

AJIL\2026 он ажил\захирамж

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 10 дүгээр сарын 06-ны өдрийн
А/248 дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Л.Санжийжамц	Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	Б.Отгонжаргал	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Ц.Мягмарсүрэн	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Б.Цогжавхлан	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Д.Хүрэлбаатар	Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
	Н.Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
	Н.Батцэнгэл	Эрх зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Ч.Магадсайхан	Газар зохион байгуулалтын албаны дарга